

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛ – НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
87.8 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ӨВА-2025/06-14-ШТА-НА



Энэхүү аудитын тайлангийн цахим
хувилбарыг дээрх QR кодоор,
тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг доорх хаягаар авна уу.
www.audit.mn, www.open.audit.mn

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын
Дарга, Тэргүүлэх аудитор **О.Батжаргал**
Утас: 70323253
Цахим шуудан: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер **П.Хорлоосүрэн**
Утас: 70323108
Цахим шуудан: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор **С.Шийлэгмаа**
Утас: 70323833
Цахим шуудан: Shiilegmaas@audit.gov.mn

Аудитор **Б.Баяртогтох**
Утас: 70323108
Цахим шуудан: Bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор **Г.Нинжбадгар**
Утас: 70323833
Цахим шуудан: Ninjbadgarg@audit.gov.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг	3
Зургийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3
Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулж, ХАА-г хууль, журмын дагуу зохион байгуулах шаардлагатай байна	7
А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 19.9 хувийг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан төлөвлөөгүй байна	7
А.2. Баталж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна	8
А.3. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсөвлөсөн байна	8
А.4. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсаар л байна	8
А.5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй байна	9
Бүлэг 2. Хөрөнгө оруулалтаар хийгдэх зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, харин бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна	12
Б.1. Гүйцэтгэгч их засварын ажлыг батлагдсан төсвийн дагуу хэрэгжүүлсэн байна	12
Б.2. Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна	14
Б.3. Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна	16
Б.4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, улсын комисс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна	17
Б.5. Нягтлан бодох бүртгэлд 2 төсөл, арга хэмжээг тусгаагүй, 1 автомашиныг зөрүүтэй бүртгэсэн байна	17
Б.6. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна	18
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	27
ЗӨВЛӨМЖ:	27

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТОӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТАХ	Төсөл, арга хэмжээ
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Худалдан авах ажиллагаанд мөрдөгдсөн журам	9
Хүснэгт 2	ОНТХО-аар нийлүүлэгдсэн авто машин, тоног төхөөрөмж /сая төгрөг/	15
Хүснэгт 3	ОНТХО-аар нийлүүлэгдэхээр батлагдсан авто машины жагсаалт	15
Хүснэгт 4	Автомашины техникийн тодорхойлолтын харьцуулалт	16
Хүснэгт 5	Хэрэгжээгүй төсөл арга, хэмжээ	17

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар	12
Зураг 2	Гучин-Ус сумын Төрийн албан хаагчийн байр	13
Зураг 3	Есөнзүйл сумын Төрийн албан хаагчийн байр	14
Зураг 4	Техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгдээгүй автомашин	16

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөрөнгө оруулалтын төрөл	7

Аудитын нэр	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
Аудитын код	ӨВА-2025/06-14-ШТА-НА Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, ХАА хууль, журмын дагуу зохион байгуулагдсан эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авч, санхүүжүүлсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар Өвөрхангай аймагт 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХБТХОХ, ГХБХБГ, ОНӨГ, ХААГ, Арвайхээр, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Уянга, Тарагт, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Есөнзүйл зэрэг сумдыг хамруулж, талбар дээр ажилласан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, баримт материалыг үзэж нотлох баримтаа цуглуулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ: АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх

	журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийж, харьцуулж, тулган баталгаажуулж, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Өвөрхангай аймаг дах Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн хэрэгжүүлж, ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Баяртогтох, Г.Нинжбадгар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын тайлангийн бүтэц	Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт зөвлөмж, холбогдох байгууллагын санал хэсгээс бүрдсэн.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14 дүгээр тогтоолоор 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталсан бөгөөд төсөвт тодотгол хийсэн 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 27/10 дугаар тогтоол, 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 29/01 дүгээр тогтоолоор тус тус хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулан баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны төсөвт батлах тухай 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад Барилга байгууламжид 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, их засварт 475.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8, автозам засвар арчлалт 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тавилга, автомашин худалдан авахад 1,060.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, нийт 2,085.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Мөн Аймгийн 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээнд 2,053.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн 2024 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах тухай 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 27/10 дугаар тогтоолоор Аймгийн 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтад байгаа Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр, шалны засварлах ажлын төсөвт өртгийг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Аймгийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 29/01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтаас Сант сумын Цэцэрлэгийн сантехникийн засварын ажлыг хасаж, Сант сумын ЕБС-ийн дээврийн засварт 63.0 сая төгрөгийн төсөвт өртгийг шилжүүлэн хэрэгжүүлэхээр баталж, тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтын 6-д заагдсан” Политехник коллежийн дотуур байрны засварын 48.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хийгдэх боломжгүй болсон тул хасаж баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 1,281.1 сая төгрөгийг, аймгийн 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээнд 1,320.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 87.8 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт **1,545.7** сая төгрөгийн зөрчил илэрч **8** албан шаардлага, **2** зөвлөмж, **241.6** сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.

Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулж, ХАА-г хууль, журмын дагуу зохион байгуулах шаардлагатай байна.


А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 19.9 хувийг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан төлөвлөөгүй байна

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2020 оны 03/03 тогтоолоор, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг аймгийн ИТХ-ын 2020 оны 03/02 тогтоолоор баталжээ.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын тогтоолоор орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 2,085.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээг, мөн төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын 2,005.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,502.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 21 төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

Нийт төсөл, арга хэмжээний 37.3 хувийг боловсрол, 5.3 хувийг эрүүл мэнд, 16.2 хувийг соёл, 23.0 хувийг нутгийн өөрөө удирдах байгууллага, 18.2 хувийг бусад салбарт хөрөнгө оруулахаар төлөвлөжээ. Үүнийг графикаар харуулбал:

Дүрслэл 1. Хөрөнгө оруулалтын төрөл



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 414.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг тусгагдаагүй байгаа нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 19.9 хувийг эзэлж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээнүүд:

- Аймгийн Цагдаагийн газрын хуучин байрны дээврийн засвар 65.0 сая төгрөг,
- Ахмадын байгууллагын тоног төхөөрөмж 55.0 сая төгрөг
- Онги-Ус суваг ОНӨХХК-д бохир соруулах автомашины шинэчлэл 100.0 сая төгрөг,
- Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж 40.0 сая төгрөг,
- Сант сумын ЕБС-ийн дээврийн засвар 63.0 сая төгрөг,
- Аймгийн дотоодын 833 дугаар тусгай салбарт техник, тоног төхөөрөмж худалдан авах 46.7 сая төгрөг,
- Онги-Ус суваг ХК-д цэвэр усны 2-р өргөлтийн насосын зардалд 45.0 сая төгрөг,

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт гэж улс болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэж заасантай нийцээгүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, бага өртөг бүхий урсгал зардалд тусгаж болох Арвайхээр сумын гэрлэн дохио, гэрэлтүүлгийн угсралт, суурилуулалтын зардалд 50.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

А.2. Баталж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөд тавигдах шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан, холбогдох хууль, журмын хүрээнд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрлээ. Үүнд:

**АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг сум, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төсөвлөсөн эсэх нь тодорхойгүй,
- Төсөвт байгууллагуудаас ирүүлсэн төсвийн санал, баримт ирүүлээгүй, төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгээр хангаагүй,
- Төслийн саналыг шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэн үнэлсэн эсэх тодорхойгүй,
- Барилга байгууламжийг магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй төлөвлөсөн,
- Их засварын зардлын төсөвт өртөг, холбогдох баримт бичигт үндэслээгүй, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэх нь тодорхойгүй,

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-г баримтлан бага өртөг бүхий, урсгал зардалд тусгаж болох зардлуудыг санхүүжүүлэхгүйгээр, тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлсэн, тооцоо судалгаатай ажлуудыг төлөвлөн батлах шаардлагатай байна.

А.3. Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төсөвлөсөн байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр 4,041.5 сая төгрөгийн өртөг бүхий 41 төсөл арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж, мөн тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байдлаар төлөвлөсөн байна.

А.4. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан боловч зарим алдаа, зөрчил гарсаар л байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258, А/259, А/261 дугаар тушаалаар батлагдсан тендерийн жижиг баримт бичгийн дагуу тендерийн баримт

бичгийг боловсруулсан боловч зарим алдаа, зөрчлүүд давтагдан гарсаар байна. Тодруулбал:

- *Аймгийн Цагдаагийн газрын хуучин байрын дээврийн засвар, Хархорин сумын ЕБ-ын 1-р сургуулийн дотуур байрны дээвэр, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн дотор засвар, аймгийн ЭМГ-ын гадна фасадын засвар-ын тендерийн архивын нэгжид тендерийн баримт бичгийг баталсан огноо тус тус байхгүй.*
- *Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдан авах 520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд багц тус бүрийн төсөвт өртгийг бүрэн оруулаагүй боловсруулсан.*
- *Хайрхандулаан сумын ЕБС-ийн дотор засвар, аймгийн Цагдаагийн газрын хуучин байрын дээврийн засвар-ын ажлын үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: шаардана” гэж тоног төхөөрөмжийн жагсаалт гаргасан боловч тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардахгүй” гэж боловсруулсан.*
- *Хайрхандулаан сумын Засаг даргын 2024 оны А/87 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь Хайрхандулаан сумын ЕБС-ийн гадна дулаан, цэвэр, бохирын засвар-ын ажлын гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичгийг боловсруулахдаа ТШЗ 18.2-т “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардахгүй”, ТШЗ 18.3-т “Тусгай зөвшөөрөл: Шаардахгүй” гэж боловсруулсан байна.*

А.5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй байна

Өвөрхангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/757 дугаар захирамжаар баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын нийт 3,672.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээнээс 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, 341.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн байна.

Тендерийг зохион байгуулахдаа нийт төсөл, арга хэмжээний 27.2 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 60.6 хувьд харьцуулалтын аргыг ашигласан байна.

Хүснэгт 1. Худалдан авах ажиллагаанд мөрдөгдсөн журам

Ангилал	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	Харьцуулалтын арга	Шууд худалдан авах
Барилга байгууламж	2	4	
Их засвар	6	11	2
Тоног төхөөрөмж	2	5	2
Дүн	10	20	4

Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны ажлын баримт

Харин дараах 174.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний шалгаруулалтад шаардлага хангасан тендер ирээгүйгээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна.

- Сант сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар
- Аймгийн ГБХХ хуримын ордон төвийн гадна ус, дулаан хангамжийн засвар

Орон нутгийн төсвөөр 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан дараах төсөл, арга хэмжээний төсвийг хуваан гэрээ байгуулан шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3¹-т заасантай нийцэхгүй байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- **Хуулийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах**- төсөвт өртөг 100.0 сая төгрөг, Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар "Хөрөнгө зарцуулах тухай" захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг болон хууль сахиулах байгууллагуудад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээний зардалд 83.5 сая төгрөгийг дараах байдлаар хуваарилжээ.
 - *Өвөрхангай аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах зардалд -20.0 сая төгрөг*
 - *Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах зардалд-15.0 сая төгрөг*
 - *Аймгийн Цагдаагийн газарт техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, сургалтын төвийн засварын зардалд-18.5 сая төгрөг*
 - *Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт техник хэрэгсэл хамгаалалтын хашаа барих зардалд-15.0 сая төгрөг*
 - *Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлийн зардалд-15.0 сая төгрөг*
- **Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн хувцас шинэчлэл**- төсөвт өртөг 80.0 сая төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/824 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Хөгжимт драмын театрын даргад шилжүүлсэн боловч тендер зарлаагүй 7 ААН, хувь хүнтэй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн.

Аудитаар аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд дараах зөрчил илэрсэн. Тухайлбал:

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- **Нарийнтээл сумын Соёлын төвийн засвар**-ын гүйцэтгэгчээр тендерийн баримт бичгийн ТШЗ 18.3-д заасан тусгай шаардлага /БА-7.1/ хангаагүй Арвайн цамхаг ХХК-ыг шалгаруулсан.
- **Зарим сумдын автозамын засвар арчлалт** /Бат-өлзий сумын төвийн 0.9 км хатуу хучилттай автозам/-ын ажлын тендерийг 2 удаа зарласан бөгөөд 1 дэх худалдан авах ажиллагааг зохион байгуулан 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Анда рөүд ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон байна. Гэтэл гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон Тулгат зам ХХК-аас Сангийн яаманд гомдол гаргажээ. Сангийн яамны 2024 оны 7 дугаар сарын 02-ний өдрийн 03/5693 дугаар гомдол хянасан тухай албан бичгийг аймгийн ХААГ-т ирүүлсэн. Уг бичигт Анда рөүд ХХК-ийн тусгай зөвшөөрөл нь 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ЗТХЯ-аас анх удаа олгогдсон байгааг нягтлуулах гомдлын дагуу туршлагын талаар ирүүлсэн мэдээллийг

¹ 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

худалдан авах ажиллагааны цахим системээс Архангай аймгийн Цэнхэр сумын ЗДТГ-аас 2023 онд зарласан тендер шалгаруулалтыг шүүж үзэхэд “Сумын төвийн асфальтбетон хучилттай автозамын ажил” нэртэй тендер шалгаруулалт зарлаагүй тул тендер шалгаруулалтын баримт бичигт тусгай зөвшөөрөл шаардсан эсэхийг хянан үзэх боломжгүй байна. Түүнчлэн Анда рөүд ХХК-ийн 2023 онд оролцсон тендерүүдийг шүүж үзэхэд тус компанийн тендерт оролцсон мэдээлэл байхгүй байх бөгөөд цахим системд 2024 оны 3 дугаар сарын 12-ны өдөр бүртгэгдсэн компани байх тул ижил төстэй ажлын туршлагад тооцсон дээрх гэрээг үнэн эсэхийг холбогдох захиалагчаас тодруулж үнэлгээнд харгалзах шаардлагатай байна. Хэрэв дээрх мэдээлэл хуурамч бол хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1 дэх заалтыг дагуу холбогдох нотлох баримт бичгийг бүрдүүлэн худалдан авах ажиллагааны улсын байцаагчид тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах саналыг ирүүлнэ үү гэжээ. Гэвч аймгийн Худалдан ажиллагааны газар нь дээрх мэдээллийг тодруулж хянаагүй бөгөөд 2024 оны 7 дугаар сарын 17-ны өдөр дахин тендер зарлаж Анда рөүд ХХК оролцож шалгарсан байна. Тус компанийн ирүүлсэн инженер техникийн ажилтнууд нь Хужирт сумын төвийн хатуу хучилттай автозамын шинэчлэлийн ажлыг гүйцэтгэх инженер техникийн ажилтнуудтай давхцаж байхад Анда рөүд ХХК-ыг шалгаруулсан байна.

- **Хархорин сумын ЕБ-ын 1-р сургуулийн дотуур байрны дээвэр, Хужирт сумын ЕБС-ийн дээвэр, Хужирт сумын 1 дүгээр цэцэрлэгийн засвар, фасад**-ны ажлуудыг гүйцэтгэх инженер техникийн ажилтнуудтай давхцаж байхад Хүүшийн гэгээ ХХК-ийг тухайн тендерүүдэд тус тус шалгаруулсан байна.
- **Аймгийн Цагдаагийн газрын хуучин барилгын дээврийн засвар, Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр, аймгийн ЭМГ-ын гадна фасадын засвар** -ын ажлыг ажлуудыг гүйцэтгэх инженер техникийн ажилтнуудтай давхцаж байхад Арвайн шагшаа ХХК-ийг тухайн тендерүүдэд тус тус шалгаруулсан байна.
- **Зүүнбаян-Улаан сумын ЕБС-ийн сантехникийн засвар, Хөгжимт драмын театрын дээврийн засвар, Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг, УТХО/-ын төсөл, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр Сонор бүрд ХХК-г шалгаруулахдаа ажлыг гүйцэтгэх инженер техникийн ажилтнуудтай давхцаж байгааг харгалзаж үзэлгүй шалгаруулсан.**

Эдгээр худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4², 26.4.1³, 50.10⁴ дахь заалтуудтай нийцэхгүй байгаа тул үнэлгээний хороод нь хууль, журам зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож, хууль журмыг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэв.

Мөн аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь Арвайхээр сумын 13 дугаар багийн 803 байрны гадна фасадын засварыг ажлын тендерт оролцогчдын ирүүлсэн цахим тендерийн материалыг ирүүлээгүй, худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан эсэхэд үнэлгээ өгөх боломж олгоогүй, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1⁵-д заасан шалгадагч этгээдийн үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

² 26.4.Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ:

³ 26.4.1 энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх;

⁴ 50.10.Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлон, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

⁵ 16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах;

Бүлэг 2. Хөрөнгө оруулалтаар хийгдэх зарим төсөл, арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, харин бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Б.1. Гүйцэтгэгч их засварын ажлыг батлагдсан төсвийн дагуу хэрэгжүүлсэн байна

Өвөрхангай аймагт орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар их засварт 2,417.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аудитад хамруулан авч үзсэн төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь батлагдсан төсөв, тоо хэмжээний дагуу гүйцэтгэсэн ч зарим ажил чанаргүй хийгдсэн байна. Үүнд:

- **Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр**-ийн ажлыг Арвайн шагшаа ХХК 142.25 сая төгрөгөөр хийхээр гэрээ байгуулан гүйцэтгэсэн боловч холбогдох норм дүрмийг баримтлаагүйн улмаас дээврийн мембран салхи орж хөвсөлзсөн, зарим хэсэгт цоорсон байдалтай байна ;

Зураг 1. Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар



Мөн орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалтын явцад гарсан эвдрэл, чанар байдлыг хянан үзэхэд дараах ажлуудыг чанаргүй гүйцэтгэсэн байна. Тухайлбал:



АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- **Гучин-Ус сумын Төрийн албан хаагчийн байр** - Оазисленд констракшн ХХК 146.0 сая төгрөгөөр барихаар 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулж гүйцэтгэсэн. Ашиглалтын явцад панелен паар цоорч, өрөөнүүдийн шал цаашид ашиглах боломжгүй болсон. Унтлагын өрөөний обойн доод хэсэг усанд норж хуулагдсан байдалтай байсан;

Зураг 2. Гучин-Ус сумын Төрийн албан хаагчийн байр






! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- **Есөнзүйл сумын Төрийн албан хаагчийн байр**-ыг ТУМБК ХХК 207.9 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулан гүйцэтгэжээ./ Санхүүжилтийн эх үүсвэр: Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 108.0 сая төгрөг, Есөнзүйл сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 100.0 сая төгрөг/ Ашиглалтын явцад дээврээс ус гоожсон, цонхны доод хэсгээр салхи сийгдэг, хөөс шахаж бөглөөгүй, сантехникийн холбох хэрэгслийг стандарт нормын дагуу хийгээгүй, хана хагарал ихтэй, дотор бохирын хоолой үнэртдэг, 00 ашиглагдахгүй, дундын цэвэр усны нөөцийн сав усаа татдаггүй улмаас ашиглалтгүй байсан;

Зураг 3. Есөнзүйл сумын Төрийн албан хаагчийн байр



Дээрх барилгын угсралтын ажлын төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 40.2⁶ дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй барилга, байгууламжийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад батлахгүй байх зөвлөмжийг аймгийн аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Мөн Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁷, 14.6⁸-д заасныг үндэслэн дээрх 2 чанаргүй гүйцэтгэсэн барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт нийцүүлж гүйцэтгэх хугацаатай албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-ын даргад хүргүүлж байна.

Б.2. Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14 дүгээр тогтоолоор “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалт”-ыг баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 835.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх 7 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. ОНТХО-аар нийлүүлэгдсэн авто машин, тоног төхөөрөмж /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Гүйцэтгэл
		Эхлэх	Дуусах		
Автомашин, тоног төхөөрөмж					
1	Арвайхээр сумын 1, 15, Бат-Өлзий сумын 3 дугаар цэцэрлэгүүдийг гал тогооны тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тоглоомоор хангах	2024	2024	50.0	49.5
2	Ахмадын байгууллагын тоног төхөөрөмж	2024	2024	55.0	55.0
3	Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардал	2024	2024	520.0	495.9
4	Богд сумын 2 дугаар сургуулийн тавилга, тоног төхөөрөмж	2024	2024	24.0	22.7
5	Хуулийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2024	2024	100.0	83.5
6	Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж	2024	2024	40.0	40.0
7	Аймгийн дотоодын 833 дугаар тусгай салбарт техник, тоног төхөөрөмж худалдан авах	2024	2024	46.7	27.0
Нийт				835.7	773.6

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

⁶ 40.2.Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.
⁷ 14.3. Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.
⁸ 14.6. Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгаар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

“Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардал” төсөл, арга хэмжээг дараах 6 багцад хуваарилсан байна.

Хүснэгт 3. ОНТХО-аар нийлүүлэгдэхээр батлагдсан авто машины жагсаалт

Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Мөнгөн дүн /сая.төг/
		Эхлэх	Дуусах		
Зарим сумдад автомашин, төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдаж авах зардал	Прокурорын газар автомашин нийлүүлэх	2024	2024	520.0	33.0
	Санхүү хяналт, аудитын албанд автомашин нийлүүлэх				53.0
	Тарагт сумын ЗДТГ-т авто машин нийлүүлэх				95.0
	Өлзийт сумын ЗДТГ-т авто машин нийлүүлэх				95.0
	Цагдаагийн газарт авто машин нийлүүлэх				220.0
	Төрийн үйлчилгээ-Мэдээллийн төвд автовишк				24.0

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Ихэнх автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээнүүд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт туссан үзүүлэлт, тоо хэмжээний дагуу ажлыг гүйцэтгэсэн боловч дараах автомашин техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу нийлүүлэгдээгүй байна.

!

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Тарагт сумын Засаг даргын Тамгын газарт “Их-өшгөр” ХХК-ний нийлүүлсэн Toyota Land cruiser 200 автомашиныг техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг шалгахад:

Хүснэгт 4. Автомашины техникийн тодорхойлолтын харьцуулалт

Техникийн тодорхойлолт	Нийлүүлэгдсэн автомашины үзүүлэлт
200,000 км-ээс гүйлтгүй байх	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын дүгнэлтийн хуудас дээр ТХ-ийн гүйлт /odometer/: 1,845,900 гэж алдаатай бичигдсэн, гэрээний бичиг баримтад 236,000 км гэж бичигдсэн, автомашин хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл дээр 183,777 км гэж бичигдсэн. /баталгаа зураг байхгүй/
Сэв, зэв болон гадна хальс замаскгүй байх	Гадна хальс замасктай, хойд хаалга сэвтэй
Пар, эйр кондешн, агаар шүүгч цэвэр байх, үрүүл, суудал халдаг, халаалтын техник, төхөөрөмжүүд хэвийн ажилладаг байх	- Мотор сольсон - Хропны диск маш муу, стачер дутуу авдаг, гар карадан муу барьдаг, дотор гэрлүүд асдаггүй - АС ажилладаггүй, халуунаар үлээдэггүй, хойд цонхнууд онгойдоггүй, нэг дугуй хавантай байна.

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Дээрх шаардлагуудыг хангахгүй байхад автомашиныг хүлээн авах комисс нь тендерийн бичиг баримтад тусгасан техникийн тодорхойлолт, чанар, ОНТ/2024-08 тоот гэрээний дагуу шаардлагад бүрэн нийцсэн байна гэж үзэн автомашиныг хүлээн авахаар

шийдвэрлэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4⁹, 26.4.2¹⁰-т нийцээгүй байна.

Иймд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст автомашиныг дахин бүрэн оношлуулах, техникийн тодорхойлолтод нийцүүлэн хүлээлгэн өгөх хугацаатай албан шаардлага хүргүүлээ.



Зураг 4. Техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгдээгүй автомашин

Б.3. Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна

Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс 5 ажил дараах шалтгааны улмаас төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

Хүснэгт 5. Хэрэгжээгүй төсөл арга, хэмжээ

д/д	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /сая төгрөг/	Хэрэгжээгүй шалтгаан
		Эхлэх	Дуусах		
1	Төрийн албан хаагчийн орон сууц барих	2024	2024	300.0	2025 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн.
2	Онги-Ус суваг ХК-д цэвэр усны 2-р өргөлтийг насосны зардал	2024	2024	45.0	2025 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн.
3	Сант сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар	2024	2024	74.0	ХАА зохион байгуулахад шаардлага хангасан тендер ирээгүй.
4	Аймгийн ГБХХ хуримын ордон төвийн гадна ус, дулаан хангамжийн засвар	2024	2024	100.0	ХАА зохион байгуулахад шаардлага хангасан тендер ирээгүй.
5	Баянгол сумын эмчийн байрны засвар	2024	2024	20.0	Эрх шилжүүлсэн. Санхүүжилт 12 сард орсон тул 2025 онд хэрэгжүүлнэ.

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Есөнзүйл сумын хөдөлмөр зусланд хийгдэх ажлыг үнэлгээний хорооны 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дугаартай дүгнэлтийн дагуу Есөнзүйл сумын Засаг даргын 2024 оны А/31 захирамжаар Мандаа гэрэлтэх рашаан ХХК-аар 29.5 сая төгрөгөөр

⁹ 26.4.Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ.

¹⁰ 26.4.2.санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

гүйцэтгүүлэхээр баталжээ. Тус ажлыг 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг дуусталх хугацаанд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ажлын явц 70.0 хувьтай байна.

Харин ажлыг гүйцэтгэх гэрээний хугацааг сунгаж, нэмэлт гэрээ хийгээгүй бөгөөд анхны гэрээний тусгай нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр алданги тооцох хувийг тусгаж өгөөгүй байна.

Б.4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, улсын комисс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтаа бүрэн хэрэгжүүлээгүй байна

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь барилга байгууламжийн их засварын ажилд техникийн хяналт гүйцэтгэх гэрээг аймгийн ГХБХБГ-тай, зохиогчийн хяналтыг зураг, төсөл зохиогчтой гэрээ байгуулж, хяналт хэрэгжүүлэх ажлын үе шатны хуваарийг баталсан байна.

Захиалагчийн хяналт буюу техникийн хяналтыг нэг барилга байгууламж дээр дундажаар 5 удаагаас доошгүй очиж хяналт хийхээр хуваарийг баталсан.

Аудитаар ашиглалтад орсон, үргэлжлэн явагдаж байгаа барилга, байгууламжуудын их засварын ажлыг газар дээр нь очиж шалгаж үзэхэд:

- Их засварын ажлын захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх явцдаа өмнөх хяналтаар илрүүлсэн алдаа зөрчлийн биелэлтийг гүйцэтгэх хугацаа өгдөггүй, барилга дээр очиж явцын хяналт хийсэн тоо хангалтгүй байна.
- Үе шатны ажилд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгчээр гаргуулж, дүгнээгүй

Зохиогчийн хяналт хийх гэрээний хавсралтад тусгагдсан хяналт хийх хуваарийн дагуу ажиллаагүй, ажлын талбар дээр 1-2 удаа хяналт хийсэн ажлын тайлан болон нэгдсэн дүгнэлтийг үндэслэн зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлыг олгосон байна.

Цаашид зохиогчийн хяналт хийх хуваарийн дагуу бодитоор хяналт хийсэн эсэхийг дүгнэн зохиогчийн хяналтын зардлыг олгож байх шаардлагатай байна.

Б.5. Нягтлан бодох бүртгэлд 2 төсөл, арга хэмжээг тусгаагүй, 1 автомашиныг зөрүүтэй бүртгэсэн байна

Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн а/77 дугаар захирамжаар хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан боловч эзэмшигч нь нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчлүүд байна. Тухайлбал:

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Аймгийн Цагдаагийн газрын хуучин барилгын дээврийн 64.7 сая төгрөгийн засварын ажлыг 2024 оны 6 дугаар сард ашиглалтад хүлээн авч, 2024 оны 12 сард хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,
- Арвайхээр сумын 13 дугаар багийн 803 дугаар байрны гадна фасадны ажлыг Онги-Өргөө СӨХ нь 46.5 сая төгрөгөөр нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,
- Тарагт сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны 7 дугаар сарын 17-ны өдөр Toyota Land cruiser 200 автомашиныг акт үйлдэж, хүлээлцсэн. Үндсэн хөрөнгийг бүртгэхдээ 98.0 сая төгрөгөөр буюу 3.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹², 14.4.2¹³ дахь заалтуудтай нийцэхгүй тул данс бүртгэлд тусгах, Тарагт сумын ЗДТГ-ын автомашины хөрөнгөд илүү бүртгэсэн үнийг залруулах хугацаатай албан шаардлагыг аймгийн Цагдаагийн газар, Арвайхээр сумын Онги-өргөө Сууц өмчлөгчдийн холбоо, Тарагт сумын ЗДТГ-т тус тус хүргүүлэв.

Б.6. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Өвөрхангай аймгийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжих 4 төсөл, арга хэмжээг 90.1 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 38 төсөл, арга хэмжээг 3,384.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас 31 төсөл арга хэмжээнд 2,601.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Барьцаа хөрөнгийн болон орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан үлдэгдлийг харуулбал дараах байдалтай байна.

- Хэрэгжээгүй 4 төсөл, арга хэмжээний санхүүжилт - *орон нутгийн ерөнхий орлогын дансанд 519.0 сая төгрөг;*
- Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар, Арвайхээр сумын гэрлэн дохио гэрэлтүүлгийн угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж дуусаагүй тул санхүүжилт-*орон нутгийн ерөнхий орлогын дансанд 143.8 сая төгрөг,*
- Зохиогчийн хяналтын зардал болон тендерийн хэмнэлт - *орон нутгийн ерөнхий орлогын дансанд 109.9 сая төгрөг,*
- Онги ус суваг ОНӨХХК-д бохир соруулах автомашин худалдан авах төсөл арга хэмжээний тендерийн үйл явц ондоо багтаж дуусаагүй, гэрээг гүйцэтгэгчтэй хийгээгүй тул - *барьцаа хөрөнгийн дансанд 85.0 сая төгрөг*

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

¹¹ 6.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

¹² 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

¹³ 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/12

Арвайхээр сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлан, аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (С.Шийлэгмаа)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Ц.Болдбаатар), аймгийн Цагдаагийн газрын дарга (Г.Чимэддагва), Хөгжимт драмын театрын дарга (Д.Түмэнжаргал), Арвайхээр сумын Онги-өргөө сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх захирал (Х.Чимэдбаяр) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (П.Хорлоосүрэн), ахлах аудитор (С.Шийлэгмаа) нарт даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Г.Нинжбадгар)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

6225010034

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
14-дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	"Хуулийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах" төсөл, арга хэмжээний зардалд 80.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/105 дугаар "Хөрөнгө зарцуулах тухай" захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болох хууль сахиулах 5 байгууллагад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээний зардалд 83.5 сая төгрөгийг хуваарилан худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	247/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	83.5
2	"Хөгжимт драмын театрын уран бүтээлчдийн хувцас шинэчлэл" төсөл, арга хэмжээний зардалд 80.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/824 дүгээр захирамжаар зарцуулах эрхийг Хөгжимт драмын театрын даргад шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	248/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	80.0
3	Аудитаар Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт хамгаалалт зэргийг үзэхэд Гучин-Ус, Есөнзүйл сумдад баригдсан төрийн албан хаагчийн байр барьж ашиглалтад өгсөн гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгж нь барилга угсралтын гэрээний дүнгийн 35.4 сая төгрөгийн төсөвт тусгагдсан ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэснээс болж ашиглалт хангалтгүй байна.	249/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	35.4
4	Аймгийн Цагдаагийн газрын хуучин барилгын дээврийн засварыг 64.7 сая төгрөгөөр "Арвай шагшаа" ХХК хийж гүйцэтгэсэн боловч барилгын засварын өртгийг санхүүгийн тайланд сайжруулалтаар авч бүртгэлд тусгаагүй байна.	250/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	64.7
5	Арвайхээр сумын 13 дугаар багийн 803 дугаар байрны гадна фасадны засварыг 46.5 сая төгрөгөөр "Хүүшийн гэгээ" ХХК гүйцэтгэсэн. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/77 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар Арвайхээр сумын "Онги-Өргөө" СӨХ-ны санхүүгийн тайланд тусгахаар шийдвэр гарсан боловч "Онги-Өргөө" СӨХ нь санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна.	251/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	46.5
6	Тарагт сумын Засаг даргын Тамгын газарт 95.0 сая төгрөгөөр худалдан авсан Ланд-200 маркийн автомашиныг санхүүгийн тайланд 98.0 сая төгрөг буюу 3.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн байна.	252/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	3.0
7	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх 1,137.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа үнэлгээний хороо нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг, холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс зөрчилтэй шийдвэр гарсан байна.	253/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	1,137.6
8	Тарагт сумын Засаг даргын Тамгын газарт орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаас 95.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Их-Өшгөр" ХХК-ийн нийлүүлсэн Toyota Land cruiser 200 автомашиныг хүлээн авах комисс нь тендерийн бичиг баримтад тусгасан техникийн тодорхойлолт, чанар шаардлагад нийцээгүй байхад хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.	254/A1560348/ ӨБА-2025/06-14-ШТА-НА	95.0
Нийт дүн			1,545.7

D:\Auditin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Холбогдох байгууллагын санал:



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2073,

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2025.05.21 № 3-3/332

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Тайланд өгөх саналгүй.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.МӨНХБАТ



6225 33 0505

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Рашаант 338, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: ghbbhg@ovorkhangai.gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn

2025.05.21 № 204
танай 2025.05.20-ны № 319 -Т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн 319 тоот
албан бичигтэй танилцлаа.

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” аудитын
тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.

ДАРГА



Т.АРИУНБОЛД

• 622502287



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2307,

Цахим шуудан: uvprocurement@ov.gov.mn,

Цахим хуудас: www.ov.hudaldan.avah.mn

2025.05.21 № 157

танай _____-ны № _____-т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн ӨВА-2025/06-14-ШТА-НА дугаартай нийцлийн аудитын төсөлд оруулах саналыг гарган хүргүүлээ.

Хавсралт №1 хуудас

ДАРГА

Ц.БОЛДБААТАР



622503076

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ОРУУЛАХ САНАЛ

2025.05.21

Арвайхээр

Танай ирүүлсэн “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д сэдэвт нийцлийн аудитын тайланд дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

1.Нарийнтээл сумын Соёлын төвийн засварын тендерийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байсан М.Санчир нь өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн. Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/522 дугаар захирамжаар М.Санчирог үнэлгээний хорооноос чөлөөлж тус газрын хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Баттөрийг томилсон. Дээрх тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр харьцуулалтын аргын дагуу 2 удаа зарласан. Шинээр томилогдсон үнэлгээний хороо дээрх тендерийг дахин зарлахдаа тусгай зөвшөөрлийг сольж БА-2.1 болгон өөрчилсөн байна. Тендерийн материалыг архивлахдаа эхэлж зарласан материалыг солилгүйгээр өгөгдлийн хүснэгтэнд БА-7.1 гэж заасан хуучин зарлагдсан баримтыг архивласан алдаа гарсан байна. Иймд дээрх тендерт гарсан зөрчлийг залруулж өгнө үү. tender.gov.mn/mn линкийг оруулав.

Тайлбарт ороогүй төсөл арга хэмжээтэй холбоотой зөрчлийг дахин гаргахгүй байх талаар анхааран ажиллах болно.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР




**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2006, 7032 2007,
Цахим шуудан: onug.uvurkhangaï@gmail.com,
Цахим хуудас: www.umch.ov.gov.mn

2025.05.20 № 62
танай _____ -ны № _____ -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт
нийцлийн аудитын тайланд санал байхгүй болно.

ДАРГА  С.ЦЭДЭНБАЛЖИР



622530092

Саналд өгсөн тайлбар:

Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 157 дугаартай албан бичгээр ирүүлсэн 1 саналыг хүлээж аваагүй, нотлох баримтаар тулган баталгаажуулсан болно.

д/д	Ирүүлсэн санал	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар
1	Нарийнтээл сумын Соёлын төвийн засварын тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр харьцуулалтын аргын дагуу 2 удаа зарласан. Шинээр томилогдсон үнэлгээний дээрх тендерийг дахин зарлахдаа тусгай зөвшөөрлийг сольж БА-2.1 болгон өөрчилсөн байна. Тендерийн материалыг архивлахдаа эхэлж зарласан материалыг солилгүйгээр өгөгдлийн хүснэгтэд БА-7.1 гэж заасан хуучин зарлагдсан баримтыг архивласан алдаа гарсан байна. Иймд дээрх тендерт гарсан зөрчлийг залруулж өгнө үү. tender.gov.mn линкийг оруулав.	1.Аудитаар тулган баталгаажуулалт хийхэд тухайн архивын нэгжид нотлох баримтыг хийгээгүй: 2. Архивын нэгжид байхгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бага өртөг бүхий, урсгал зардалд тусгаж болох зардлуудыг санхүүжүүлэхгүй байх, тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлсэн, тооцоо судалгаатай ажлуудыг төлөвлөх шаардлагатай байна.
2. Үнэлгээний хороо нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.
3. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс 5 ажил төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна.
4. Төсөл арга, хэмжээнд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч гүйцэтгэгчийн гаргасан зөрчил дутагдалд хариуцлага тооцохгүй байгаагаас ажлыг чанаргүй хийх байдал давтагдан гарч байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бага өртөг бүхий, урсгал зардлын шинж чанартай ажлыг санхүүжүүлэхгүйгээр тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлсэн, тооцоо судалгаатай ажлуудыг хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлэн төлөвлөж байх;
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг төсөв нь магадлалаар баталгаажсан барилга, байгууламжийг батлаж, хуулийн шаардлагад нийцүүлэх;